

## ЭРДЭНЭЦАГААН СУМ

2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

### **Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийн мэдээлэлийг 2023 оны 6 дугаар сарын мэдээлэлтэй харицуулж Эрдэнэцагаан вэб сайт, пейж хуудсанд байршуулсан ба энэ хугацаанд 2 иргэнээр зээл хаалгаж 23031285 ₮ орлого оруулан ажилласан.

Тамхины тусгай зөвшөөрөл сунгах хоёр аж ахуй нэгжийг зөвшөөрлийг олгосон.

Аймгийн ХХАА-н газрын 7 хүний бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтын багийнхантай хамтарч Хүнсний худалдаа, Сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд хяналт хийж ажилласан.

Төлөвлөгөөт хяналтанд ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний 2 дэлгүүр, эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалтанд Мал төхөөрөх цех буюу бойны газар- 1, 1,2-р цэцэрлэгүүд, сургуулийн ойролцоох түргэн хоолны газар, Цэцэрлэгийн ойролцоох 1 дэлгүүр тус тус шалгагдаж урьдчилсан дүгнэлтээр бага эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан..

Малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулах, үйл ажиллагааг нь дэмжин хөгжүүлэх, харилцан туршлага солилцуулах, сумын шилдэг бүтээгдэхүүн бий болгон “Сумын 100 жилийн ойн гарын бэлэг, идээ ундааны зүйлд захиалга өгч бэлтгүүлэх” зорилгоор “Алтан намар, Эрдэнэцагаанд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаа, Нээлттэй хаалганы өдөрлөгийг 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн, ЗДТГ-ын пейж хуудсаар иргэд олон нийтэд мэдээллийг хүргэж ажиллаж байна.

### **Ерөнхий боловсролын чиглэлээр:**

. ЕБС-ийн V-VI ангид англи хэлний хичээл заах 120 багшид “Perason English connect” дижитал платформын сургалтанд англи хэлний багш Б.Мөнхмарал хамрагдсан.

Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслөөс сургуульд суурилсан энтерпрайз хэрэгжүүлэгчид туршлага солилцох сургалт зохион байгуулагдсан.

БШУГ-тай хамтран Математик, нийгмийн тухай мэдлэг хичээлүүдээр ЭЕШ-ын амжилттай бэлтгэх гарааны урьдчилсан сорил зохион байгуулагдсан.

Эрүүл мэндийн төвтэй хамтран 1-р ангийн 4 бүлгийн 127 сурагчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэгт хамруулсан.

Ахлах ангийн сурагчид мэргэжлийн боловсрол эзэмшихээс гадна хичээлээс гадуурх нэмэлт сургалт дугуйлангийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор after school платформ дээр 9-12-р ангийн сурагчдыг хамруулахаар бэлтгэж байна.

ЕБС-ийн 3-4-р ангид математикийн нэмэлт хөтөлбөр EDUTEN хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдаж, 3,4-р ангийн 8 багш онлайн сургалтанд хамрагдаж байна.

### **Соёлын чиглэлээр.**

Соёл, урлагийн ажилтны баярыг тохиолдуулан Байгууллага сурталчилах арга хэмжээ буюу "Нээлттэй Хаалганы өдөрлөг" 9 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд: Шилдэг Соёлын биет болон биет бус өв тээгч нар, Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудыг алдаршуулж хүндэт өргөмжлөл, Соёлын түшиг холбооны одон медалиар шагнаж урамшууллаа.

Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болсон язгуур соёл, өв уламжлал, төрт ёсны түүхээ дээдлэн хамгаалж төрөлх монгол эх хэлээрээ зөв ярьж, зөв бичих, эх хэл, түүх соёлоо сурталчлах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 9-р сарын 1-ний өдрийг "ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР" болгон зарласантай холбогдуулан Х. Гүндсамбуугийн нэрэмжит номын сан нь "ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР"-ийг зохион байгуулан ажилласан.

Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Соёл урлагийн салбарын ажилчдын "СОЁЛ-СПОРТ" өдөрлөг 2023 оны 09 сарын 15,16 - ны өдрүүдэд амжилттай болж спортын 4 төрөлт тэмцээнээр хүч авьяасаа сорьж өрсөлдлөө.

Соёлын төвийн дэргэдэх хөгжим , бүжгийн дугуйлан нийт 18 хүүхдийн бүрэлдэхүүнтэй долоо хоног бүрийн Даваа, лхагва , баасан гариг бүр 10:00 , 15:00 цагуудаас тогтмол хичээллэж байна.

**Мал эмнэлэгийн тасаг:** Сумын Засаг даргын 2023 оны 08-р сарын 10-ны өдрийн А/186 тоот "Хонины цэцэг" өвчний дархлаажуулалт хийх захирамжны дагуу 715 өрхийн 72202 хурга төлөвлөснөөс одоогоор 615 өрхийн 58130 толгой хурга тариж

80,5%-тай гүйцэтгэлтэй хийгдэж байна. Мөн аймгийн Засаг даргын 2023 оны 08-р сарын 15-ны өдрийн А/495 тоот Бруцеллёзын дархлаажуулалт хийх тухай захирамж гарсны дагуу 785 өрхийн Тугал-10990, Хурга-55180, Ишиг-50940, Нийт-117110 мянга мал төлөвлөснөөс 71447 мянган мал тарьж 61%-тай гүйцэтгэл хийгдээд явж байна. Аймгийн мал эмнэлгийн газраас лабораторийн баг хамт олон ирж 3205 хээлтүүлэгчээс шинжилгээ авсан.

### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

**2023 оны 09-р сарын байдлаар** 35 эхийг жирэмсний хяналтанд авч 35 эхийг эхний 7,6,9 сартай хяналтанд хамруулснаар жирэмсний эрт хяналтын 100% хувь Хяналтанд орох үеийн жирэмсний голч хугацаа 9.4 неделя байна. Жирэмсэн эхчүүдийг ЭМС-ын 318-р тушаалын дагуу хянаж нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 12,20,32 неделд нь үзлэгт хамруулж өртөмтгий бүлгийн жирэмсэн эхчүүдийг төрөлжсөн мэргэжлийн эмчийн хяналтанд шилжүүлэн төрүүлж байна. Сумын эрүүл мэндийн төвд 6 эх төрсөн.

**Сэргээн засах эмчилгээгээр нийт 62 хүн эмчлүүлсэн**

**Халдварт өвчнөөс сэргийлэх вакцинд нийт 114 хүнийг хамруулсан.** Сургалтыг 504 хүнд хийж зөвлөгөө өгөв.

Сувилахуйн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 1725 хүнд үзүүлсэн.

Монгол улсын засгийн газрын 224-р тогтоолыг хэрэгжүүлэх, эмч эмнэлгийн ажилчдад мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 9-р сарын 6-нд -Гепатитын вирусийн халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэлт -Элэгний бүтэц ба үйл ажиллагаа, элэгний эмгэгийн үед илрэх шинж тэмдэг, гепатитийн талаарх ерөнхий ойлголт сэдэвт дотоодын сургалтуудыг дарга Г. Энхтуяа удирдан зохион байгууллаа. Сургалтанд эмч эмнэлгийн ажилчид 100% хамрагдав.

### **. Гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр**

2023-2024 оны хичээлийн шинэ жилд Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах 15 хүүхдийн судалгааг гаргаж явуулав.

Хүүхэд хамгааллын 108 мэдээллийн утсанд ирсэн дуудлагын дагуу тухайн хүүхдэд кейс нээн цагдаагийн байгууллагын албан хаагчтай хамтран гэр бүл болон хүүхэдтэй уулзаж холбогдох нөхцөл байдлын үнэлгээнүүдийг хийсэн.

7-р багийн иргэн өрх толгойлсон эмэгтэй Ё.Алтанцэцэгийн бага охины баруун нүд хараагүй болж Улаанбаатар хотод хагалгаанд орох шаардлагатай болсон учир дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

#### **Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**

Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй ажил хайгч иргэдийн мэдээллийг шинэчилэн сэргээсэн. Шинэ ажлын байр 190, зуучлал 70 иргэнд хийсэн.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд шинээр төрсөн 15 хүүхэд, тэтгэвэр болон цалинтай эхийн хугацаа сунгасан 9 иргэн, цалинтай аав 1, жирэмсэн эхэд 7 иргэн бүртгэсэн.

Ахмадын асаргаа 6, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа 2, ахмадын сувилал 3 ахмад, шүд хийлгэсэн 6 ахмад, харьяалалгүй 482 ахмадыг ахмадын баярын хүндэтгэлд шивсэн.

#### **ХАА-н чиглэлээр:**

Аймаг сумын засаг даргын мөрийн хөтөлбөр, сумын засаг даргын захирамжийн дагуу бог малын хээлтэгч 1500 толгой, хээлтүүлэгчийг 100 хувь бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 1-р багийн 5 өрхийн 1200 хээлтэгч /эм хонь/, 550 толгой хуц, 230 толгой ухныг бүртгэлжүүлэн ээмэглэлээ. Малчдын мал сүргийн сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ХААГ-тай хамтран Сэлэнгэ аймгийн Хушаат сумаас махны чиглэлийн Хар ангус 2, сүү махны чиглэлийн Сименталь үүлорийн 3 бухыг 3,5,7-р багийн өрхүүдэд үхэр солилцоогоор өгсөн Монгол улсын түүхий музейтэй холбогдож Үзэмчин хонины чихмэл хийлгэх ажлыг эхэлж байна.

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.